

Жозеф Стиглиц хөгжиж буй улс орнуудын эдийн засаг, улс төрийн бодлогод хийсэн анализыг Монгол Улсын өнөөгийн байдалтай дүйцүүлэн харах нь

Ч.Өлзийсайхан

Доктор, дэд профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим.

Д.Ундрах

Доктор, дэд профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим.

Монгол Улсад улс төрийн эдийн засгийн ухаан хэрэгтэй юм уу, хэрэггүй болоод л 1990 оноос хойш ерөөсөө хөгжөөгүй юм биш үү дээ?

Шок эмчилгээгээр муужруулан сэхээгээд улс орноо хөгжүүлэх тухай үлгэр ярьж 27 жилийг өнгөрөөж одоо ч энэхүү бодлогоо зөв гэж тайлбарлахыг оролддог, ядуурал нь тэгэж байгаад баян болгоход аяандаа хүргэдэг гэж номлодог эдийн засагчид, улс төрчдөд биш харин баялагт татагддаг, баян амьдрахыг хүсдэг, баялгаа зөв зарцуулж хүний зэрэгтэй амьдрахыг хүсдэг хэн бүхэнд улс төрийн эдийн засгийн ухаан хэрэгтэй юм. Баялаг гэдэгт ард түмэнд бурханаас заяасан баялгийг нь өөртөө авсан юм уу, өрөөл бусдад дамжуулан зуучлахдаа хөлжиж авсан хүмүүсийн хурааж хуримтлуулсан хөрөнгийг биш харин ерөөсөө улс орон зөв бодлогоор, зөв замаар өөдөө дэвшин хөгжиж, тусгаар тогтнол аюулгүй байдлаа хамгаалахад гарцаагүй хүргэж байдаг тэр баялаг, тэр хөрөнгийн тухай өгүүлэх нь зүйтэй юм.

Хүмүүс элбэг хангалуун амьдрах гэвэл нэг бол үйлдвэрлэл хөгжинө, нэг бол дээрэм хөгжинө. Үйлдвэрлэл хөгжвөл нийгмээрээ баян болно, дээрэм хөгжвөл нэг хэсэг нь л баян болно гэдэг нь улс орнуудын түүхээр нэгэнт нотлогджээ. Дээрмийг ганц нэг, хэсэг бүлэг хүмүүсийн ёс суртахууны хэм хэмжээгээр тайлбарлаж болохгүй. Энэ нь дээрмийн хэмжээ нь олон улс орнуудын үгүйрэл доройтлын эх сурвалж болж байдаг учраас энэ нь улс төрийн эдийн засгийн ухааны хамгийн чухал асуудал мөн. Энэ нь нийгмийн байгууллыг төгөлдөр болгоход саад болж хэсэг бүлэг хүмүүсийн амьдрах арга болж үүнийгээ улс төрийн эрх мэдлээр баталгаажуулж, нийгмээр хүлээн зөвшөөрүүлэх хууль эрх зүйн тогтолцоог бий болгож, эргэх аргагүй болгож байдгаараа хамгийн аюултай юм. Үүнийг нээж илрүүлэх, мөн чанарыг нь тайлбарлах, засч залруулах нь улс төрийн эдийн засгийн ухааны зорилго ач холбогдол оршиж байна.

Эдийн засгийн ухаан дан ганц ил харагдах тоон үзүүлэлтээр зөв үр дүнг харуулж чаддаггүй болохыг Оюутолгой, Бороогоулд, Сентеррагоулд, Хөшөөт.. гэх мэт олон уул уурхайн компаниуд дээр гаргасан алдаатай шийдвэрүүд бэлхэнээ нотлож байна. Тэгвэл сайн эдийн засгийн бодлого хэрхэн яаж гарах юм бэ? Энэ бол татвар, цалин, бараа нийлүүлэлт гэсэн тоо биш харин дагалдан гарах үр дагавар бүрийг нь тооцсон улс төрийн эдийн засгийн ухаан л байх болно. Энэ нь ойрын үедээ сайн биш ч ирээдүйд сайн үр дагаварт хүргэх гарцаагүй зөв бодлого байх бөгөөд энэ нь улс төрийн институцийн зөв бүтэцтэй л холбоотой гарч ирнэ. Эсвэл муу бүтцийг эвдсэн ганц нэг улс төрийн хошуучлагчийн амь эрссэн ширүүн тэмцлийн дүнд гарч ирж болно. Ийм улс төрийн хошуучлагч өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх аль ч шатанд үрэгдэж мэдэх ч бодлогын зөв зам руу оруулсан гавьяа нь улс орныг зөв зам руу эргэлт буцалтгүй оруулж болдог. Ард түмэн ч, улс төрийн хошуучлагч ч, хувь хүн ч ялгаагүй аз жаргалд хүрэхийн тулд ямар хэмжээний үнэ цэнэ төлөх вэ гэдгийгээ мэдэх ёстой.

Дан ганц өнөөдрийн ашиг хонжооны төлөө ирээдүйгээ баллаж болохгүй буюу эдийн засгийн үр дүнг тооцохдоо зөв улс төрийн бодлого барих ёстой. Ардчилсан нийгэм тогтсоноор хууль ёс, шударга ёс үнэхээр ноёрхож бүх зүйл сайн сайхан болох бөгөөд төрийн үүрэг роль улам хумигдах ёстой юм уу?

Энэ талаар

“Нэг талаас боолчлол үеэ өнгөрөөж байна. Нөгөө талаас хэдийгээ рөөрийн хөрөнгөө хамгаалах боломж хүн бүр толдох болсон ч гэлээ, хүмүүний анхны араншингийн гойд чанар болсон ил цагаан хулгай дээрэм бага ч гэсэн байсаар л, тэр нь чухамдаа ажлын хүндийг бусдад үүрүүлэх, өөрөө бол ач буяныг нь хүртэх муу зангаар илэрсээр л байна. Дарангуйлагч хүн өнөөдөр хэнийг ч өөрийнхөө гараар багалзуурдаад унахаа больжээ. ...Дарангуйлагч, түүний золиос хоёр өдгөө ч байсаар, гагцхүү дундуур нь Төр, өөрөөр нэрлэвэл, хууль гээч юм шургаад орчихож.

Төр гэдэг бол агуу их хуурмаглалын бөөгнөрөл агаад, түүний зуучлалын үр дүнд хүн бүхэн бусдынхаа ашгаар амь зуухыг оролдоно”¹⁵⁴

гэж Бастиа дахин чухал санаа хэлж байна.

Хичнээн ардчилал ярьсан ч ардчилсан бус дэглэмд байснаасаа илүүтэйгээр төрөөр дамжуулж өөрийнхөө эд хөрөнгийг зузаатгах гэсэн түшмэд, сайд нар, тийм араншинтай хүмүүсээр төрийн алба дүүрч байна. Нийгмээс хүлээлгэсэн үүрэг хариуцлага нь өөрт нь ямар их ашиг унагааж болохыг ойлгож, хүмүүсийн хувь заяаг хуваарилагч болж ард түмнээсээ ихийг авч, түүнээсээ нилээд хэсгийг нь өөртөө хуваарилан авч байна. Энэ боломжийг илүү олж авахын тулд илүү данхар бүтэц, илүү холбоо сүлбээтнээр энэ алба нэмэгдэн өсч бэхжиж байна. Нийгэм үүнийг харсан ч яаж ч чадахгүй болж байна. Энэ бүх үр дүн, ашиг орлого, зарцуулалт нь эдийн засгийн энгийн тооцооллоор мөн чанараа харуулна гэж байхгүй. Нийгмийн асар их баялаг хэдий хэмжээгээр ард түмнээс хүнийсч, авах эрхгүй хүмүүс рүү хууль журмаар хаацайлагдан очсон, ард түмэн хэдий хэмжээгээр хохирч хэр зэрэг орлого олж чадсан гэдэг үнэн тооцооллыг ямар ч эдийн засаг ч гаргаж өгөхгүй. Уг нь гаргаж тооцоолж чадах ч энэ нь төрд буй хүмүүсийн эрх ашгийг ямагт хөндөх учраас тогтолцоо нь гажигтай үед энэ үнэ тооцоолол илрэхгүй.

Үүний мөн чанарыг олж харах билгийн нүд улс төрийн эдийн засгийн ухаанд л бий. Эдийн засгаас улс төрийн эдийн засгийн ухааны ялгагдах гол зүйл бол эдийн засаг нь тоо, тооцоололд түлхүү ач холбогдол өгдөг бол, улс төрийн эдийн засгийн ухаан нь бодлогод илүү ач холбогдол өгч байдгаараа ялгагдана. Ард түмэнд ирж буй өчүүхэн хэсэг нь тэдэнд бурханаас өгсөн баялгийн хулгайнаас яавч илүү гарч чадахгүй. “Төр авснаасаа илүүг буцааж өгнө гэж хэзээ ч байхгүй” гэдэгт уйлын үнэн билээ”¹⁵⁵.

Төр ард түмэнд юу ч өгөхгүй, дандаа ихийг аваад байна гэж байхгүй. Ямар нэг хэмжээгээр өгнө. Өгөхгүйгээр авна гэвэл тэр төр унах цаг нь болсон, өдрөө тоолон хүлээж байгаа гэсэн үг. Харин хэр зэрэг их авч, хэр зэргийг өгөх юм бэ? Өгч байгаагийн хэмжээ нь авч байгаа нь уучилж болохуйц хэмжээнд байвал энэ төрийн тогтвортой байж болно. Уучилж болохуйц хэмжээний тухайд ард иргэдэд өгч байгаа хэмжээ нь амьжиргаанд нь сэтгэл ханамжтай байхаар байж болно, тэр хэмжээнд биш ч аюулгүй байдлыг нь хангах түвшинд байж болно, шударга ёсны хэмжүүрт нийцэж байна гэвэл тийм эдийн засгийн бодлого үргэлжилж болно. Энэ нь мөн л эдийн засгийн тооцооллоор бол утгагүй тоо харагдах боловч, улс төрийн эийн засгийн үүднээс бол утга учиртай байх нь эргэлзээгүй.

Адам Смитийн өгүүлснээр төр бол

- Олборлох,
- боловсруулж, үйлдвэрлэх,
- Тээвэрлэх,
- Жижиглэнгээр хуваарилах харилцааг зохицуулах чухал үүргийг гүйцэтгэнэ.

Энэ явцад нийгмийн баялгийн нилээд хэсэг нь зам зууртаа алга болно. Шашин давамгайлсан нийгэмд бол юу нь тодорхойгүй, байгаа үгүйг нь хэн ч шалгахгүй зүйл, зорилгод энэ баялаг чиглэгдэнэ. Харгис капитализмын үед нийгмийн олонхи хэсгийг нь мөлжих замаар

¹⁵⁴ФредерикБастиа “Илхарагдах, үлхарагдахУБ., 2014. 88 дахьтал.

¹⁵⁵Мөн тэнд 93 дахь талд

цөөхөн хэсэг дэндүү ихийг халаасална. Энэ нь орчин үеийн дэлхий ертөнцөд ч байгаа, түүнийг нь нийтээрээ колоничлол, шинэ колоничлол гэдэг. Улс орны дотоодод улс төр, эдийн засгийн давуу эрхтэй бүлэглэлүүд өөрсдөдөө давуу байдал бий болгож байгаа бол энэ нь орчин үеийн сайхан нэрээр халхавчлагдах бөгөөд тендер, концесс, сонгон, менежментийн хувьчлал, зээл, төсөл, хөнгөлөлт гэх мэт янз бүрийн нэрээр халхавчилсан байна. Нийтийн баялгийг өөрсдөө авах, хэн нэгэнд зуучлан өгөх замаар дээрэмдэх үйл ажиллагаа нь хуулиар халхавчлан хийгддэг тул жирийн иргэд хууль ёсны дагуу үйл ажиллагаа гэж ойлгож тэдний баялаг яаж үрэгдэж байгааг ойлгохгүй өнгөрөх нь элбэг. Хэрэв нийгмийн хэмжээгээр бусармаг зүйл дэндүү газар авсан бол вч байгаа хүмүүс нь ч дээрэм хийж байгаагаа бараг мэдэхгүй болох түвшинд заль мэх, хэвшил болжирдэг бололтой. Энэ заль мэх, төөрөгдлийн цаад мөн чанар, утга учир, арга хэлбэрийг нийтээрээ мэддэг болсон цагт л давуу байдал эрх мэдлээ ашиглах явдлыг хязгаарлаж чадна. Үүнийг олж харах, ард түмний баялгийг хадгалж байх, нийгмийн эмх замбараагүй байдлаас сэргийлэх баталгаа бол улс төрийн эдийн засгийн ухаан л байх болно. Жан Жак Руссо “Бидний ойр орчинд болдог үзэгдлүүдийг олж харах чадвартай байхын тулд маш сайн философич байх хэрэгтэй” гэсэн байдаг. Өөрөөр бодит байдлын учир шалтгаан, хөгжих хөгжихгүйн учир шалтгааныг олж харьяа гэвэл цаад мөн чанарыг нь ойлгох ёстой гэсэн үг.

Дан эдийн засгийн тооцоолол, эсвэл дан ганц улс төрийн шинжлэх ухааны судлагдхуунууд дангаараа гажуудсан эдийн засгийн учир шалтгааныг харуулж чадахгүй байж мэдэх л юм. Жишээ нь улс төрийн намын тухай, сонгуулийн систем, сонгуулийн технологийн тухай хичнээн яриад ч хөгжихгүй байгаагийн учир шалтгааныг олж харж чадахгүй байж болох юм. Харин улс төрийн эдийн засгийн ухааны үүднээс эдийн засгийн шийдвэрүүд, улс төрийн институц түүний бүтэц бүрдэл гэх мэт цогцоор нь харвал асуудлын мөн чанар илүү тод харагдах юм.

Улс орон нэгэнт хөгжихгүй замаар ороод эхэлсэн бол эрх баригчдын сайн дураар энэ байдлыг өөрчилнө гэж бараг байхгүй. Тэдний сүсэг бишрэл нь, эсвэл өрөвч нинжин сэтгэл нь гэнэт ард түмнээ бодоход хүргэнэ гэж байхгүй. Хэрэв ийм зүйл байдаг бол хүний мөн чанар нь их өөрчлөгдөж бурханлаг болсон байх ёстой. Гэтэл аль ч шашныг шүтдэг байсан ялгаагүй, хүн төрөлхтөний сайн сайхны төлөө, бурханы сургаалийг дагаж байна гэж залбиравч аль ч шашин ноёрхсон бай ялгаагүй баян хоосны ялгаа хаана ч байсаар л байна. Харин сүсэг бишрэл, сайхан сэтгэлд итгэж найдсан биш харин хүний хэзээ ч гарч ирж мэдэх амин хувиа хичээсэн үйлдлийг хязгаарлан барих боломжтойгоор төрийн институтээ бий болгож чадсан улс орнууд л тогтвортой хөгжлийг хангаж чадна. Ард түмэн аль нь зөв аль нь буруу вэ гэдгийг олж харах чадвартай, гашуун туршлагаараа мэдэрсэн байвал байдлыг засч чадна. Харин ард түмэн энэ шударга бус зүйлийг хууль ёсны, алдар гавьяаны зиндаанд аваачаад тавьчихвал ёс суртахуунч байхгүй, хөгжил дэвшил ч байхгүй болно гэсэн үг юм.

Монгол Улсын үе үеийн засгийн газраас хэрэгжүүлж байгаа “зээл авч хөгжих” гэдэг бодлогыг улс төрийн эдийн засгийн ухааны сонгодог төлөөлөгчид хэрхэн үзэж байсан юм бэ, бид энэ тал дээр зөв алхам хийж байгаа юу гэдгийг улс төрийн эдийн засгийн ухааны хамгийн анхны алхам болгож дүгнэлт хийхийг оролдоё. “Зээл авах нь ирээдүйгээ булшилна гэсэн үг, гэвч энэ цаг үед энэ нь дээрхи хоёр амлалтандаа (1. Аль болох их жаргал, 2. Ямар ч) хүрэх цорын ганц арга хэмжээ болоод байгаа, өөрөөр хэлбэл, ирээдүйн их хороор өнөөдрийн бага буяныг бүтээж болно. Энэ бол дампуурлын шинж тэмдэг. Тэгэхээр одоо яах вэ? Шинэ төр маань зоригтой алхамуудыг хийхээс өөр аргагүйд хүрнэ. Хүчний байгууллагуудаа татан авчраад олон нийтийн санал бодлыг багалзуурдана, хүчирхийллийн аргыг сонгон авч “урьд үзэгдээгүй аргаар удирдахаас аргагүйд хүрлээ” гэж зарлана, товчоор хэлэхэд бүхнийг удирдан жолоодох аргад шилжинэ¹⁵⁶ гэж Бастиа 200 гаруй жилийн өмнө бичиж байжээ. Тэрээр эдийн засаг, улс төрийн богино хугацааны үр дүн нь түүнээс үүдэн удаан хугацааны, урьдчилан

¹⁵⁶ФредерикБастиа “Илхарагдах, үлхарагдахУБ., 2014. 95 дахьтал.

тооцоолсноос хамаагүй их хор хохиролыг дагуулж болохыг олон жишээгээр тайлбарлаж байсны нэг нь өрийн асуудал байдаг.

Энэ эрдэмтний өрийн тухай санаа орчин үед хэрхэн яаж хэрэгжиж байна. Бид энэ эрдэмтдийн санааг, бодит түүхийг хэр зэрэг харж судласан юм бэ, бодлого маань зөв юм уу, түүний хэлснийг тоогүй мөртлөө түүнээс эсрэгээр ярьсан хүмүүсийн санаа бодлыг яг зөв гэж үзэх нь зөв юм уу, үр дүн нь хэнийх нь зөв гэдгийг бодитойгоор харуулж байна вэ гэх мэт олон асуулт урган гарна. Асуудлыг нэг тийш болгохын тулд бодит баримт дээр ярих ёстой. Үүний нэг том жишээ бол олон улсад Вашингтоны зөвшилцөл гэж нэрлэгддэг бодлого юм. Латин америкийн гол орнуудад хэрэгжүүлж эхлээд дараа нь хөгжиж буй бараг бүх оронд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр орнууд 1960, 1970-аад оны үед америкийн банк санхүүгийн байгууллагуудаас ихээхэн хэмжээний өр зээл тавьсаар хуримтлагдсан өр нь 1980-аад он гэхэд төлөх боломжгүй болсоор эдийн засгийн гүн хямралд орсон. Иймээс энэ өрийг америкийн банкуудад эргэн төлүүлэх зорилгоор боловсруулсан Вашингтоны Зөвшилцөл гэх хөтөлбөрөөр одоо манай улсад бараг адилхан хэрэгжүүлж айгаа бодлогуудыг явуулсан. Үүнд: төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн нийгмийн зардлыг багасгах, татварын тогтолцоонд өөрчлөлт хийх, мөнгөний ханшийг бодитой болгож чөлөөлөх, гадаадын шууд хөрөнгө оруулалтанд таатай нөхцөл бүрдүүлэх төрийн өмчийг хувьчлах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах хязгаарлалтуудыг багасгах гэх мэт арга хэмжээнүүдийг авахаар тусгасан. Энэ нь өрийг төлүүлэхэд л чиглэгдэж байсан. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр эдгээр орнуудын эдийн засагт шинэ дэвшил авчрахын оронд харин ч богино хугацаанд ядууралд хүргэсэн сөрөг үр дүнд хүрсэн байдаг. ОУВС, Дэлхийн банк энэ бодлогыг 2011 онд буруу байсныг хүлээн зөвшөөрсөн. Гэтэл манай улс одоо энэ бодлогыг хэрэгжүүлсээр, дэлхийн улс орнууд ингэж өр зээлээр хөгждөг гэж сурталчилж төр засаг нь яг ийм бодлого хэрэгжүүлж байгааг юу гэж ойлгох вэ. Энэ байдал бол улс төрийн эдийн засгийн ухаан нь өөрөө хөгжихгүй байгаа, үүргээ гүйцэтгэж чадахгүй байгааг л харуулна.

Монгол Улсын байгалийн баялгийн экспортын хэмжээ хэдэн зуун километрт хүрэх хэмжээгээр гадагш урсч байгаа ч улс орон валют, мөнгөний нөөцгүй, ард иргэдийн амьдрал сайжирч өгөхгүй байгааг юу гэж тайлбарлах вэ? “Юу ч оргүй хоосноос үүсэхгүй ба ул мөргүй алга болохгүй. ...хэн нэг нь алдвал нөгөө нь олж байна гэсэн үг. Хэрэв хэн нэг нь олсон бол өөр нэг нь алдсан байж таарна. Энэ нь эд баялаг эргэлдэж байна гэсэн үг юм¹⁵⁷...”

“Хоосрохын хууль ийм байдаг: баялгийг хадгалж хамгаалах нь олж хуримтлуулахаас хамаагүй хэцүү. Хямрал, зах зээлийн таагүй учир байдал, өрсөлдөгчид, монополийн эсрэг хуультай улс, шинжлэх ухаан технологийн дэвшил, тэрчлэн муу хүүхнүүд болон зүсэн зүйлийн луйварчид гээд олон гадаад дайсан бий. Харин удирдлага залуургүй байх, эд баялагт хайхрамжгүй эсвэл нухацтай хандахгүй байх нь хоосрох “дотоод хүчин зүйлд” тооцогддог. ... Нэг үгээр хэлбэл, мөнгөний амьдрал ердөө гайхсаар үлдэхээр тийм хэцүү¹⁵⁸...” Нийтийн баялгийг захиран зарцуулах эрх олж авсан этгээдүүдэд тавих хяналт байхгүй, эсвэл хяналт тавих этгээдүүд нь бас хяналт тавьж чадахааргүй доройтсон, хамсаатан болсон байвал нийгмийн зүгээс гайхах тээнэгэлзэх байдал хичнээн ихсэн тусам баялгийг зувчуулж ашиг унагаагчид нь айж зовох зүйлгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх бөгөөд үүнийгээ илүү их хууль ёсны шинжтэй болгож, нийгмийн өмнө гэм зэмгүй нэгэн болж харагдах ажиллагаагаа улам төгөлдөржүүлж өнгөлөн далдлах болно. Олон түмнийг хууль ёсны үйл ажиллагаа явуулжээ гэж бодохуйцаар төөрөгдүүлж сохроор итгүүлдэг байна.

Муу төрийн бүтэц нарийн зохион байгуулалттай үед энэ хууран мэхлэх үйл ажиллагааны хэлбэр нь дэндүү олон болж салаалж зувчуулагчдын талд хөрөнгө зузаарахын хирээр төр нь улам хүчирхэгжиж, өргөжих хандлагатай болно. Гэхдээ тэднийг тэжээж буй хүч

¹⁵⁷Валирия Башкирова, Александр Соловьев. Дэлхийн хэмжээний дампуурал хоосрол” УБ., 2011, 7-8 дахь тал.

¹⁵⁸Валирия Башкирова, Александр Соловьев. Дэлхийн хэмжээний дампуурал хоосрол” УБ., 2011, 8-9 дэх тал.

хөрөнгө нь ард түмнийх л байх бөгөөд ард түмний зовлон улам л зузаарна. Энэ хэрээр үйлдвэрлэл, эд баялаг, сайн сайхан амьдрал итгэл найдвар, тусгаар тогтнол, өөрсдийгөө хүндлэх ухамсар нь мөхсөөр байх болно. Үүнийг аврах ганц зүйл бол эдийн засгийн байдлын улс төрийн учир шалтгааныг ойлгож мэдэж авч өөрчлөх буюу улс төрийн эдийн засгийн ухаанаар гэгээрэх явдал байх болно.

Төлөөллийн байгууллага л зах зээлийн эдийн засаг шиг бүх зүйлийг сайхан болгох ид шидтэн гэвэл энэ нь бас л гэнэн төөрөгдөл байх болно. Төлөөллийн байгууллагууд амжилтанд хүрэхийн тулд их удаан хугацаатуулах нь дамжиггүй, Монгол Улсад л лавтая өдий болтол тэр зорилгоо биелүүлээгүй байна. Үүний учир шалтгаан нь эрх мэдэлтнүүд цагүргэлжмашсэрэмжтэйбайдаг, харинардтүмэнямагттуршлагагүй, гэнэн, хууртагдахад амархан байдгийнх байж болно. Засгийн газар өөрсдийн бусармаг үйл ажиллагаагаа явуулахын тулд хардлага төрүүлэхгүй байх бүх аргыг хэрэглэдэг бөгөөд маш сэрэмжтэй, ажил хэргээ чадварлаг, хэрэглэх арга нь зохицолдсон, маш сайн бодож эрэгцүүлсэн төлөвлөгөөтэй, улам төгөлдөржсөн, туршлага дадлагатай болж байгаагийн зэрэгцээ ард түмнийхээ зан араншин, хүсэл мөрөөдлийг сайтар судлаж байна. Одоо бол олон нийтийн санаа бодлыг судлах судалгаа, хэвлэл мэдээлэл эрчимтэй хөгжсөн нь эрх баригчдад улам их боломж олгож байгаа. Тэд өөрсдийн үйл ажиллагаагаа нууж хааж байхын тулд хоорондоо эв ээтэй бие биенийгээ илчлээд өгчихөөргүй хэмжээнд хоорондоо сүлбэлдсэн байх л хэрэгтэй болж байна.

Засгийнгазар албантушаалуудыгхуваарилах, тэтгэвэрмэтийнхэмжээгтогтооход, тендер концесс мэтийг хуваарилах мэтийн л ажил хийхээс биш ард түмний хүсээд байгаа хэлээд байгаа зүйлийг ерөөсөө хийхээр оролдох ч үгүй, оролдсон ч нэр төдий л хийж байна. Засаг төр улам нүсэр болсоор ард түмэн улам илүү зүтгэсээр, олон түмний төлөө юм шиг нэртэй улам олон байгууллагууд бий болсоор л, гэтэл амжиргааных нь түвшин хэвээр, магадгүй улам доройтсоор байгаад гайхсаар л суух нь хэвээр л байна шүү дээ. Үүний учир шалтгаан бол бдит байдал, хөгжихгүй байгаагийн жинхэнэ учир шалтгааныг олж харж чаддаггүйд л байгаа юм.

Харин ард түмэн өөрсдөө хийж чадах ганц зүйлээ хийхдээ хэрхэн яаж ханддаг вэ? Засгийнэрхийгбарих, засгийн газрын үйл ажиллагааны хүрээг тодорхойлох, хөлс шагналын хэмжээг тогтоох хүмүүсийг сонгох болох үед ард түмэн хэнийг сонгодог вэ? Мөн л өнөөх өөрсдийнх нь төлөө сэтгэл гаргаагүй төрийн түшмэдийг л сонгосоор байдаг. Тэр завсар амьдралынх нь нөхцөл байдал улам л муудсаар, эцсийн бүлэгт ард түмэн хорон үйлийг хэрхэн засахыг биш, харин тэр хорон үйлийг хэрхэн дэмжихээ л бодох нь ойлгоход бэрх. Гэхдээ үүнийг сонгуулийн технологи, сонгогчдын санаа бодолд судаалгаа хийдэг байгууллагууд судлаачид учрыг нь олж дөнгөдөг бөгөөд хэрхэн яаж тийм сэтгэлзүй бий болгохоо ч сайн сэдэх болжээ.

Дэлхийн Банкны дэд тэргүүн, АНУ-ын Ерөнхийлөгчийн эдийн засгийн зөвлөх Стиглиц дэлхийнхүнбүр, ялангуяаядуухүнийгбаянчинээлэгболгоххүччадал дэлхийчлэлийн нөхцөлд эдийн засгийн зөв бодлого явуулахад л бий гэж үзсэн бөгөөд улс орнуудын эдийн засгаа хөгжүүлэхэд гаргадаг улс төрийн бодлогын томоохон алдаануудыг тоочсон байдаг. Энэ бүх алдаануудыг манай улс нэг бүрчлэн гаргасан тул Стиглицийн олж харсан зүйлүүдийг өөрийн орны хөрсөнд буулган жишиж үзсэнээ тоочье.

Улс төрийн эдийн засгийн ухааныг эрүүл саруул ухаанаар судлаж шинжлэхгүйгээр 27 жил болоход бидний гаргасан алдаанууд юу вэ? Өөрсдөө алдаагаа олж харахаас бусдын гаргасан алдааг бид давтаж байна уу гэж харах нь илүү хялбар байх болов уу. Иймд эдийн засагч Стиглицийн ядуу орнуудад гарсан алдаануудыг нарийвчлан судласан бөгөөд энэ нь манай улсын улс төрийн эдийн засгийн бодлоготой нэг их зөрөөгүй нийлдэг нь харамсалтай зүйл юм.

Стиглиц худалдааны хориг саадыг арилгаж либерал бодлогыг тууштай явуул гэсэн гадныхны зөвлөгөөгөөр үйлдвэрлэлээ дэмжсэн худалдааны бодлого байхгүйгээр амьдарснаар үндэсний үйлдвэрүүд өсч хөгжиж чаддаггүй явдлыг хөгжиж буй орнуудад түгээмэл гардаг том алдаа гэж үзсэн. Өндөр хөгжилд хүрсэн улс орнуудын худалдаан дээр баримтласан бодлогын түүхийг харвал үргэлж хамгаалалтын бодлоготой явж ирсэн. Өнөө үед ч бараа бүтээгдхүүнд

тавигдах стандартаар дамжуулан худалдааны хоригийн бодлого үндсэндээ хэрэгжсээр л байдаг. Харин хөгжиж буй улс орнууд худалдааны хориг ч байхгүй, бараа бүтээгдхүүнд тавигдах стандарт шаардлагууд, түүнийг хянах шалгах явдал ч хангалттай бус. Эдгээр улсуудад авилгын түвшин өндөр байдаг нь худалдааг үндсэндээ сул чөлөөтэй болгож байдаг. Энэ нь эргээд эдгээр орнуудын үйлдвэрлэлд хүнд цохилт болж байдаг учраас үйлдвэрлэл хөгждөггүй, үүний үр дагавар ажилгүйдэл, ядуурал улс орны салшгүй нэг шинж болж хувирдаг байна. Өнөөгийн Монгол Улсын үйлдвэрлэлийн байдлыг харвал цөөн хэдэн улс төр эдийн засгийн сүлбээтэй цөөн хэдэн үйлдвэрүүд, тэр тусмаа архи, уул уурхайн түүхий эдийг шууд экспортод гаргадаг цөөн хэдэн хүн л баяжсан. Үйлдвэрлэл хөгжөөгүй тул ядуурал, ажилгүйдэл, цагаачлал нийгмийн хамгийн хүнд асуудал болж, цагаачлалын байдал нь хүйсийн тэнцвэр алдагдаж, үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлөх хэмжээнд хүрч байж болзошгүй гэж сэтгэл зовоох асуудлын нэг болж ирж байна. Стиглиц дэлхийн худалдааны бодлогод байгаа шударга бус байдлыг шүүмжилсэн хөгжиж буй орнуудын шүүмжлэлийг огт тоогоогүй, хөгжиж буй орнуудын бараа бүтээгдхүүнүүд өндөр хөгжилтэй орнуудад нэвтрэхэд байдаг бэрхшээлийг тооцоогүй гэж шүүмжилсэн нь үнэхээр манай улсад хэрэгжсэн.

Хөгжиж буй орнууд эдийн засгийн ямар бодлого ямар үр дүнд хүргэдэг болохыг нотлох баримтад тулгуурлан судладаггүй. Эдгээр орнууд ямар ч томоохон бодлого хэрэгжүүлээ гэсэн төсөлд оролцож буй дэлхийн хэмжээний том компаниудын үзүүлэх гэсэн зүйл, нотлох гэсэн зүйлээр хязгаарлаж шийдвэр гарч байсан нь улс үндэстнээрээ хохирол амссан гэрээ хэлцэлүүд хийхэд хүргэдэг гэж Стиглиц үзсэн. Өнөөгийн Монгол Улсын засгийн газруудын байгуулсан гэрээ хэлцэлүүд нь ард түмэнд ашиггүй, байгаль орчин, баялгаараа хохироод үлддэг гэрээ хэлцэл хийсэн болохыг Бороо Гоулд, Төмөртэй, Оюу толгой, Хөшөөт, Дачин тамсаг.. гэх мэт олон гэрээнүүдээр нотлож болно.

Стиглиц посткоммунист орнуудад шилжилтийн эдийн засгийг маш буруу явуулсан нь тэдний эдийн засагт маш их хүндрэл авчирсан гэж үзсэн Үнэхээр ардчилал, зах зээл, чөлөөт эдийн засагт шилжихдээ манай улс төрийн зохистой, бодлогыг явуулж чадаагүй. Цочир эмчилгээгээр өөрийн орны онцлогийг харгалзан үзэж үндэсний эдийн засгаа хамгаалж бөөцийлж өндийлгөх биш, нэгэнт бий болсон байсан үйлдвэрлэх хүчний нөөц, потенциалыг эвдлэн өрсөлдөх чадваргүй болгох бодлогыг явуулсан. Энэ бодлогыг хэрэгжүүлэгчид өөрсдийн хийсэн зүйлийг хичнээн зөв гээд ч буруу болох нь цаг хугацаагаар нотлогдож байна. Зах зээлийн эдийн засаг аяндаа хөгжилд хүргэнэ гэдэг үзэл дэлхийн улс төрийн эдийн засгийн ухаанаар няцаагдаж байхад үүнийг мэдээгүй, судлаагүй, нэрэлхэж асуудлыг шийдсэн. Монгол Улсын засгийн газар өөрийн хүссэнээрээ зөв бодлого явуулаагүй, бүхий л цаг үед гадаадын хандивлагч, туслагч, хөрөнгө оруулагч нарт барьцаалагдаж ирсэн. Энэ нь авилгад өртсөн этгээдүүд улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж улам гарцгүй болж бомилогдсоор байсантай ч бас холбоотой. Сайнэдийн засгийн бодлогоболсайнулстөрийнбодлогогэдгийг няцааж хоёр өөр зүйл шиг нийгэмд ойлгуулж ирсэн. Сайн эдийн засгийн бодлогыг өөрийн орны онцлог, ард түмний аж байдалтай уялдуулан эрүүл саруулаар эрэгцүүлээгүй зөвхөн зөвлөмж дагаж ажилласан нь энэ байдалд хүргэсэн.

Ж.Стиглиц ОУВС-ийн төсөл, хөтөлбөрүүдэд байнга эргэлзээтэй хандаж ирсэн. Тэдний бодлого ихэнхдээ улс орнуудад сүйрэл доройтол авчирсан болохыг олон баримтаар нотлон өгүүлсэн байдаг. Гэтэл манай улс ОУВС-ийн явуулж буй бодлогууд өөр улс орнуудад ямар үр дүн өгсөн бэ гэдгийг эрэгцүүлж үзээгүй. Тэдний бодлогыг шүүн хэлэлцдэггүй явж ирсэн, зөвхөн тэдний санхүүжилтийг алдахаас айсан, 4 жилийн хугацаанд амь аргацааж дахин сонгогдохоо л бодохоос улс орны ирээдүйг улс төрийн эдийн засгийн эрүүл ухаанаар шийдээгүй. Баян орныг улам баян, ядуу орныг улам ядуу болгох бодлогоо хүчээр тулгадаг тусламжуудын мөн чанарыг одоо ч ойлгохгүй, эсвэл ойлгосон ч үүний эсрэг юу ч хийж чадахгүй явж байна.

Эдийн засагч маань хөнгөлттэйзээл, худалдааныквотын цаг хугацаа, үр дүн, ашиглах боломж зэргийг тооцож үзэлгүйгээр энэ бүх ажиллагааг хэрэгжүүлж байгааг шүүмжилсэн байдаг. Манай улсын улс төрийн тогтолцооны сул дорой байдал нь хөнгөлттэй зээлийг ч зүй

зохистой ашиглах боломж олгоогүй, худалдааны квотыг ч ашиглах нөхцлийг бүрдүүлж өгөөгүй. Энэ худалдааны квотыг жишээлбэл, хятад улсын оёдлын үйлдвэрүүд чадамгай ашиглаж квотод хамрагдсан богино хугацаанд монголд үйлдвэр байгуулж ажиллачихаад явчихсан. Үүнийг нь бас л хөрөнгө оруулалт, чөлөөт зах зээл гэсэн байдлаар л тайлбарласан. Өөрсдийн үйлдвэрүүд бахь байдгаараа хоцорсон билээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Ерөнхийлөгчийн албан тушаалыг хүлээж авсны дараахан АНУ-аас Монгол Улсад сууж буй элчин сайдтай уулзаж ярилцахдаа АНУ-аас урьд нь манай улсад үзүүлж байсан худалдааны квот нь үндэсний үйлдвэрүүд дөнгөж эхлэлийн шатанд байх үетэй давхцсан нь энэ салбарт дэмжлэг болж чадаагүй. Одоо ийм хөнгөлөлт нэн шаардлагатай байгаа тул энэ талаар туслана уу гэсэн хүсэлт тавьж байсан нь үүнийг нотлон харуулна.

Олон улсын банк санхүүгийн байгууллагаас авсан өр зээлүүд нь эргэж баялаг бүтээх салбарт зарцуулагддаггүй, тодорхой болзолтойгоор орж ирдэг нь хөгжиж буй улс орнуудад сүйрэл авчирдаг болохыг Стиглиц олж харсан. Үнэхээр одоогийн байдлаар монгол улсын өрийн хэмжээ 27 тэрбум долларт хүрсэн байгаа ч энэ өр зээлээр улс орны эдийн засгийг өргөх нэг ч томоохон үйлдвэр ашиглалтанд ороогүй. Үйлдвэрлэлд биш эргэж мөнгө олж бүтээгдхүүн үйлдвэрлэх боломжгүй дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, ядуурал, утаа, цахилгаан станцын шинэчлэл гэх мэт зүйл рүү зарцуулагдсан. Үйлдвэрлэл рүү зарцуулагдсан цөөн хэдэн төсөл, улс төрчидтэй хамааралтай бизнес бол хөлөө олж дөнгөсөн, тэгэж чадаагүй хүмүүсийн хувьд бол худалдааны төрийн бодлогын алдаатай холбоотойгоор дампуурал руу хөтлөсөн зүйл болж хувирсан.

АНУ, Япон гэх мэт олон АҮ-жсэн орон гадаадын компаниудтай өрсөлдөхийн өмнө зарим аж үйлдвэрээ ухаалгаар сонголт хийн хамгаалж байж эдийн засгаа хөгжүүлсэн. АНУ-ын өөрсдийн үйлдвэрлэл худалдаагаа хамгаалсан түүх нь АНУ-ыг өөрийг нь тусгаар улс болгох тэр үетэй хамт явагдсан эртний түүхтэй байдаг. Дотоодын бүх үйлдвэрээ хамгаалах гэсэн орнууд амжилтанд хүрээгүй нь үнэн боловч, мөн худалдааны хоригийг нэн даруй хүчингүй болгосон орнууд ч амжилтанд хүрээгүй. Ийм түүхийн бодит жишээг манай улс тоогоогүй, харин яг эсрэгээрээ ажилласан.

Хөгжиж байгаа орны зах зээлийг бусад орны хамаагүй хүчтэй АҮ-ийн салбартай өрсөлдөх нь өөрт нь хохирол авчирч болзошгүй АҮ-ийн зарим салбарын бүтээгдхүүний өрсөлдөж болох импортын бараанд хөгжиж буй орны зах зээлийг нээхийг шаардах нь нийгмийн хувьд ч, ЭЗ-ийнхувь ч хөнөөлтүрдагавардагуулна. Улсорны АҮ, ХАА-н салбар хүчтэй хөгжиж ажлын шинэ байр бий болж чадахгүй байхад хөгжиж буй орнуудын ядуу фермерүүд Европ Америкийн орнуудын өндөр татаастай бараа товартай өрсөлдөх чадваргүй байдаг тул эдгээр оронд ажлын байрыг зориудаар үгүйхийсээр байдаг тухай улс төрийн эдийн засгийн ухааны хамгийн энгийн ойлгомжтой зүйлийг тоогоогүй, зах зээлээ зоргоор нь орхисон.

Стиглиц хөгжижбуйорныг жижигзавьтай зүйрлэн хэлсэн байдаг. Эдгээр улсууд ОУВС-ийн шаардаж буй арга барилаар хөрөнгийн зах зээлийг яаралтай чөлөөлөх нь хөгжиж буй орнуудыг хөлөг онгоцны их биеийг нь засч тордоогүй, ахмадыг нь сургаж дадлагжуулаагүй, аврах хувцасыг нь онгоц дээр бэлэн болгоогүй байж хөлөг онгоцыг ширүүн давалгаат далайд алс холын аялалд гаргана гэсэн үг. Хамгийн аятай нөхцөлд ч аварга том давалгаа тэднийг эрэг дээр гаргаж хаях магадлал өндөр юм гэж тэрээр үзсэн байдаг.

Өнөөдөр Монгол Улсын гадаад өрийн хэмжээ 27 тэрбум долларт хүрч зарим улстөрчдийн ярьж байгаагаар дампуурлаа зарлах хэмжээнд хүрсэн байхад олон улсын банк санхүүгийн байгууллагууд яагаад манай улсад зээл олгосооор байгаа юм бэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Тэгвэл энэ өр зээлийн бодлого нь баялаг ихтэй ч хөгжил буурай улс орнуудыг зориуд хүнд байдалд оруулах гэсэн байдаг юм бишүү гэсэн эргэлзээ Стиглицийн бүтээлээс илт харагдаж байдаг. Тэрээр гадаадын тусламжийг удирдлагаар хангаж чадахгүй байгаа орнуудын онцлог нь эдийн засгаа хүртэл удирдаж чаддаггүй. Нэгэнт эдийн засгаа удирдаж чадахгүй юм чинь гадаадын тусламж, зээл тусламжийг ч эрүүлээр зарцуулах боломжгүй гэдэг нь ойлгомжтой байхад олон улсын байгууллагууд маш их хэмжээний зээлүүдийг өгч байна гээд үүнийгээ Этиопын жишээн дээр тайлбарласан. Тэрээр олон улсын

банк санхүүгийн байгууллагууд Этиопыг эдийн засгаа эрүүлээр удирдаж байхад нь зээл олгоогүй харин зүй зохисгүй удирдах болсноор их хэмжээний зээл өгч Этиопын эдийн засгийг сүйрүүлсэн гэж шулуухан хэлсэн байна. Харин Ботсвана улс үндэснийэвнэгдлийнгүнзгийухамсартүндэслэсэнулс төрийн зөвшилцлийг тогтоон барьж зөвлөхүүдийг шалгаруулж авахдаа маш нягт нямбай сонгож авсан. 1981 оноос хойш Ботсвана ОУВС-д дахин хандаагүй. Дэлхийн банкнаас Ботсванагийн засгийн газарт ажилласан хуульч нь Ботсванагийн эсрэг ажиллаж байхад нь засгийн газрын зүгээс өөрийн боломжит бүх хүчийг ашиглаж эрх ашгаа хамгаалсан. Хөгжиж буй орнуудад хандах ОУВС-ийн хандлагыг зүйрлэвэл ямар хандлагатай төстэй вэ. Гол төлөв колонилогч удирдагчдынхтай төстэй хандлагатай гэж бичсэн байна.

Стиглицийн хөгжиж чадахгүй байгаа улс орнуудын эдийн засаг, улс төрийн байдал, олон улсын банк санхүүгийн байгууллагуудын харилцааны асуудалд анализ хийсэн нь өнөөгийн манай улсын төрөөс баримталж байгаа бодлогуудтай харьцуулан үзвэл сэтгэлээр унамаар дүр төрх ажиглагдаж байна. Манай улсын эдийн засгийн бодлогод гарсан алдааг тоочиход 60 орчим ноцтой алдаанууд байгааг анзааран харж байна. Энэ тоо цааш хэд болж нэмэгдэхийг хэлж мэдэхгүй байна. Энэ эрэгцүүллийг нэг өгүүлээр бүгдийг харуулах боломж гүй бололтой. Зөвбодлогыггаднаасавчирчболдоггүйюм. Бид өөрсдөө ухаалаг улс төрийн эдийн засгийн бодлогогүйгээр сайн зүйлийг олж авах гэдэг ихээхэн бэрхшээлийг дагуулна гэдгийг л дүгнэн хэлж чадах байна. Үргэлжлэл бий.

Ном зүй:

Ж.Стиглиц. Дэлхийчлэл ба түүний сэтгэлд эс нийцэх нь. УБ., 2012.

ФредерикБастиа “Илхарагдах, үлхарагдахУБ., 2014.

Валирия Башкирова, Александр Соловьев. Дэлхийн хэмжээний дампуурал хоосрол” УБ., 2011

Д.Цолмон. Америкийннэгдсэнулсынтүүх. УБ., 1999.

Б.Санжмятав Дэлхийн эдийн засаг. Өнөөгийн байдал, хөгжлийн хандлага, зохицуулалт. Хоёрдахь хэвлэл. УБ., 2015

The Economics of the Developing Countries. Н.Мyint. 5th ed. London. 2012

Myltinational Companies and the Third World. Louis Turner. 1975.NY.